

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2009 ОНД
ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН БИЕЛЭЛТ**

2009.12.25

Булган аймаг

Бодлогын зорилт	Бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ	Биелэлт
НЭГ. БОДИТ САЛБАРЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО		
<p>Хүн амыг эрүүл хүнсээр бүрэн хангах зорилгоор мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлж, бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуйг хослуулан хөгжүүлж, мал аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, боловсруулалтыг нэмэгдүүлж, хүнсний гол нэрийн бүтээгдэхүүнээр дотоодын хэрэгцээгээ хангах бодлого баримтлана</p>	<p>Өрхийн аж ахуйгаас бэлтгэсэн илүүдэл төмс, хүнсний ногоо, мах, сүү, цагаан идээ боловсруулах, татвар, түрээсийн төлбөргүй хүнсний зах, салбар, цэгүүдийг аймаг сумын төвүүдэд байгуулж ажиллуулах</p> <p>Экологийн цэвэр сүү, цагаан идээ, мал болон гахай, тахианы мах, махан бүтээгдэхүүн, өндөгний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж “Сүү” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлж эхлэх</p>	<p>Аймаг сумын түвшинд үзэсгэлэн худалдаа зохион байгуулж өрхийн үйлдвэрлэлээр бэлтгэсэн төмс хүнсний ногоо, сүү цагаан идээг талбайн түрээсийн төлбөргүйгээр худалдаалах арга хэмжээнүүдийг зохион байгуулж хэвшээд байна.</p> <p align="right">/Хэрэгжилт 80.0 хувь/</p> <p>“Экологийн цэвэр бүтээгдэхүүн” дэд хөтөлбөр боловсруулж аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтаар ханган ажиллаа. Манай аймаг байгалийн хувьд харьцангуй цэвэр, унаган төрхөө хадгалсан мал аж ахуй, газар тариалангийн үйлдвэрлэлийг байгаль орчин хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөлгүй технологиор эрхэлдэг учир хөдөө аж ахуйн болон байгалийн гаралтай бүтээгдэхүүнүүд нь экологийн цэвэр бүтээгдэхүүнд тавигдах шаардлагад бүрэн нийцэж байна. Аймгийн “Сүү” дэд хөтөлбөрийн хүрээнд “Хүүхэд бүрт аяга сүү” аяны удирдамж боловсруулж холбогдох мэргэжлийн байгууллага, агентлагуудад хүргүүлэн хэрэгжилтэнд хяналт тавин ажиллаа. Экологийн цэвэр мах сүүний хангамжыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Мянганы хөгжлийн сорилын сангийн "Хот орчмын бэлчээрийн төсөл"-өөр Сэлэнгэ, Хангал, Орхон, Бугат, сумдад мах сүүний чиглэлийн эрчимжсэн аж ахуй байгуулах бэлтгэл ажлыг хийж</p>

		<p>байна. Сүү сүүн бүтээгдэхүүний хангамжыг нэмэгдүүлэх болон боловсруулах үйлдвэрлэлийг дэмжиж 10 төсөлд 144,0 сая төгрөгийн хөнгөлттэй зээлээр дэмжлэг үзүүлсэнээс Хишиг-Өндөр суманд Франц, Монголын иргэдийн хамтарсан “Гүми Хишиг - Өндөр” ХХК 800 гаруй сая төгрөгний хөрөнгө оруулалтаар импортыг орлох экспортод чиглэсэн сүү сүүн бүтээгдэхүүн, бяслаг, гүүний хуурай саамны үйлдвэр барих ажил эхлүүлж барилга угсралтын ажил 70 гаруй хувьтай үйлдвэрийн тоног төхөөрөмжийг оруулж ирээд байна. Мөн “Эгийн Хишиг” ХХК цөцгийн тосны цехийн үйл ажиллагааг эхлүүлж “Зулзаган түшиг” ХХК үйлдвэрлэлийн байрны барилгын засвар үйлчилгээг хийх тоног төхөөрөмж худалдан авах, Сайхан, Могод сумдад эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан айраг эсгэн савлах үйлдвэр, борлуулалтын сүлжээ бий болгох бизнес төслүүдэд дэмжлэг үзүүлсэнээр үйлдвэрийн байраа засварлаж 20 мянган тн айраг нөөцөлж тоног төхөөрөмжөө захиалаад байна. 4-6 дугаар саруудад аймгийн төвийн хүн амд эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан орчинд бэлтгэгдсэн экологын цэвэр хямд үнэтэй мах нийлүүлэх ажлыг “Эрдэнэт прогресс” ХХК- тай гэрээ байгуулж “Од”ХХК, “Булган хүнс” ХХК, “Булган Анар” ХХК-ий дэлгүүрүүдээр дамжуулан худалдааллаа. Үйлдвэрийн орчинд бэлтгэсэн мах махан бүтээгдэхүүний хангамжыг нэмэгдүүлэх бодлогын аймгийн төвд мал мах бэлтгэлийн нэгдсэн цэг, хөргүүртэй зоорийн төсөлд 50,0 сая төгрөгний хөнгөлттэй зээл олгосоноор үйлдвэрийн барилга угсралтын ажил 90,0 гаруй хувийн биелэлттэй байна. “Хутаг-Өндөр мах маркет” ХХК хөргөлтийн тоног төхөөрөмжөө шинэчилж аймгийн төвийн хүн амд хагас боловсруулсан дайвар бүтээгдэхүүн нийлүүлэхээр ажиллаж байна. Эко- фермерийн аж ахуй байгуулахад 80,0 гаруй сая төгрөгний дэмжлэг үзүүлсэнээр “Хар тарлан” үүлдрийн үнээтэй аж ахуй шинээр байгуулагдаж,</p>
--	--	---

		<p>Хангал сумын “Арвин сан”, Бугат сумын Ц.Хасбаатар, Хутаг-Өндөр сумын Д.Алтанхуяг, Рашаант сумын н.Жанчивдорж, Сэлэнгэ сумын Ганзүрхийн фермерийн аж ахуйнууд үйл ажиллагаагаа өргөжүүллээ. Аймгийн төвд томоохон хүчин чадалтай 50,0 сая төгрөгнөөс дээш санхүүжилт шаардлагатай мал мах махан, сүү сүүн, хүнс гурилан бүтээгдэхүүний үйлдвэр байгуулах төслүүдийг ХХААХҮЯ-д хүргүүлж шаардлагатай хөрөнгийн асуудлыг шийдвэрлүүлэхээр бэлтгэж байна</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100.0хувь/</p>
<p>Агаар ус хөрсний бохирдол, орчны дориотолыг бууруулах, хянах тогтолцоог боловсронгуй болгоно</p>	<p>Аймгийн төв болон төвлөрсөн суурингийн гэр хорооллыг барилгажуулахаас бусад газруудыг зөвхөн нээлттэй дуудлага худалдаагаар худалдах тогтолцоонд шилжих</p>	<p>Аймгийн хэмжээнд нийт 3 удаа газрын нээлттэй дуудлага худалдаа зохион байгуулж, амралт сувиллын зориулалтаар 3.7 га газрын эзэмших эрхийг 23.6 сая төгрөгөөр, үйлчилгээний зориулалтаар 0.107 га газрын эзэмших эрхийг 2 сая 89 мянган төгрөгөөр тус тус иргэд, аж ахуйн нэгжид өгч нийт 25 сая 689.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт орууллаа.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100.0 хувь/</p>
	<p>Усны нөөцийг нэмэгдүүлэх, мод бут сөөг тарьж ургуулах ажлыг эрчимжүүлэх</p>	<p>Аймгийн хэмжээнд гол горхины дагууд 110 тн хог хаягдлыг цэвэрлэж, 61 булаг шанд, рашааны эхийг хашиж, хамгаалах арга хэмжээ авлаа. Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийн хүрээнд Дашинчилэн суманд 10 га газарт 5000 ширхэг мод бут тарьж, 2 худаг гарган усалгааны асуудлыг шийдвэрлэлээ. Аймгийн мод бутны хэрэгцээг хангах зорилгоор БОАЖГазрын дэргэдэх мод үржүүлгийн газрын ил талбайд чацаргана 3300 ширхэг, бургас, улиас тус тус 4000 ширхэгийг тариаллаа.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100.0 хувь/</p>
	<p>Усан сан, хөв байгуулах, мод бут сөөг тарьж ургуулах ажлын үр дүнг сайжруулан арчлах, хамгаалалтыг сайжруулах</p>	<p>Аймгийн ИТХ-аар модны жишиг үнийг тогтоолгон албан байгууллага, ард иргэддээ хямд сайн чанарын модоор хангаж ажилласны дүнд нийт 20658 ширхэг модыг шинээр тарьсны дээр 2714.65 м2 газрыг зүлэгжүүлж, усан арчлан хамгаалж ажиллаж байна. Дашинчилэн, Рашаант болон Хишиг-Өндөр суманд шинээр хөв байгуулж, бэлчээр, хадлангийн талбайн усан хангамжийг нэмэгдүүллээ.</p> <p style="text-align: right;">/Хэрэгжилт 100.0 хувь/</p>
<p>ХОЁР. ЯДУУРЛЫГ БУУРУУЛАХ, ХҮНИЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ БОДЛОГО</p>		

Хүн амын хөгжлийг ханган, амьдралын дээшлүүлэх хөгжлийг хүний чанарыг	Хүүхдийн амны хөндийн эрүүл мэндийг сайжруулах зорилгоор шүдний кабинет байгуулах ажлыг дэмжиж хэрэгжүүлэх	Сум дундын эмнэлгүүдэд “Хүүхдийн шүдний кабинет” байгуулах бэлтгэл шатны ажил хийгдлээ.Шүдний кабинетэд шаардагдах тоног төхөөрөмжийн судалгааг нарийвчлан гаргаж, ЭМЯ, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа “Дэлхийн-зөн” байгууллагад хүсэлт гаргасан. ХЯБХ-ийн санхүүжилтээр “Явуулын шүдний амбулатори” ажиллуулж, өнгөрсөн жилд 4 суманд нарийн мэргэжлийн эмчийн үзлэгийг зохион байгуулан 5 00 хүүхдийг хамруулан, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулсан.Хишиг-өндөр сумын шүдний эмчийг нарийн мэргэжлийн эмчийн мэргэшүүлэх 6 сарын сургалтанд хамрагдсан.Хишиг-өндөр, Хутаг-өндөр, аймгийн Нэгдсэн эмнэлгийн шүдний кабинетээр 3000 хүн үзсэнээс 2400 хүнийг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулж, эрүүл мэндийн сурталчилгаа хийж, сурталчилгааны материал тараасан. / Хэрэгжилт 80.0 хувь/
	Нийтийн биеийн тамир, спортын материаллаг баазыг өргөтөгөхөд дэмжлэг үзүүлэх, нийтийн биеийн тамир, спортын талаар төрөөс баримтлах бодлогыг батлуулж, хэрэгжүүлж эхлэх	Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр гарсан Засгийн газрын 05 тоот тогтоолыг хэрэгжүүлэх аймгийн Засаг даргын захирамжийг гарган, өнгөрсөн онд нийтийн биеийн тамирын 50 арга хэмжээнд 6000 хүнийг хамруулаад байна. Сумдын ЗДТГ-т нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх чиглэлээр зөвлөмж хүргүүлэн ажиллаж, аймгийн Засаг даргын захирамжийн дагуу сар бүр нэрэмжит ажлуудыг зохион байгуулан “Аялах дэвтэр” аялуулж үр дүнг тооцон ажилласан. Аймгийн хэмжээнд биеийн тамир спортын талаар 2009-2012 онд баримтлан ажиллах бодлогыг боловсруулан гаргаж, нийтийн биеийн тамирыг түлхүү хөгжүүлэх зорилтыг тусгасан.Зорилтын хүрээнд аймгийн хэмжээнд зохимон байгуулах ажлын төлөвлөгөө гарган ажиллалаа. / Хэрэгжилт 100.0 хувь/

Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2009 оны үндсэн чиглэлийн биелэлт 94.3 хувь

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

